



**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2018 оны 6 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар А/119, А/377

Улаанбаатар хот

**СУРГАЛТЫН АГУУЛГА, ТӨЛӨВЛӨГӨӨ, ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ**

Хувийн хамгаалалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Мэргэжлийн боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.9 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хувийн хамгаалалтыг биечлэн гүйцэтгэх боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэжлийг нь дээшлүүлэх сургалтын агуулга, төлөвлөгөө"-г нэгдүгээр, "Хувийн хамгаалалтын сургалт явуулах зөвшөөрөл олгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Тушаалыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын дарга /цагдаагийн хурандаа С.Баатаржав/, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Г.Баясгалан/, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /С.Мөнхөөлэй/ нарт тус тус даалгасугай.

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД Ц.ЦОГЗОЛМАА**